



Index: ASA 30/002/2014

## МОНГОЛ УЛС

НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэгт зориулсан илтгэл  
Ажлын Хэсгийн 22 дугаар хуралдаан 2015 оны 5 дугаар сар

### ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2010 онд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгээр (ЭДХ) гишүүн улсуудаас Монгол улсад өгсөн 129 зөвлөмжийн 126-г нь хүлээн авч баталж, 3-г<sup>1</sup> нь хэрэгжүүлэхээс татгалзсан.

Монгол улсын засгийн газар 2011 оны 5-р сард ЭДХ-ийн зөвлөмжийг 2011-2014 онд хэрэгжүүлэх Үндэсний төлөвлөгөөг баталсанд Эмнести Интернэшнл талархаж байна.<sup>2</sup> 2012 оны 3-р сард Монгол улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах авах ялыг халах тухай Нэмэлт II Протоколыг соёрхон баталсан.<sup>3</sup>

Монгол улсын засгийн газар эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцах явдалтай тэмцэх зөвлөмжийг хүлээн авсан ч, цагдаа нарын хүч хэрэглэсэн үйлдлийг бүрэн дүүрэн хараат бусаар мөрдөн шалгах аа баталгаажуулах амлалтаа хэрэгжүүлээгүйд Эмнести Интернэшнл харамсаж байна.<sup>4</sup> Мөн Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба(УЕПДМБА)-ыг татан буулгаснаар Монгол улсад эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бусаар харьцсан хэргийг мөрдөн шалгах хараат бус механизм дутагдаж байна. Энэ нь цаашид хүч хэтрүүлэн хэрэглэсэн хууль сахиулах ажилтнууд, хүний эрхийг зөрчигчид ял шийтгэлгүй үлдэх явдлыг улам нэмэгдүүлэх вий хэмээн Эмнести Интернэшнл санаа зовниж байна.

Эмнести Интернэшнл нь Монгол улсын засгийн газраас Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны Конвенц, түүний 1967 оны Нэмэлт Протокол, түүнчлэн Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцийг соёрхон батлах зөвлөмжийг хүлээж аваагүйд мөн харамсаж байна.<sup>5</sup>

### ҮНДЭСНИЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТОГТОЛЦОО

#### Үндэсний хууль тогтоомж

Монгол улс үндэсний хүний эрхийн тогтолцоогоо сайжруулах хэд хэдэн алхам авсны нэг нь 2014 оны 7-р сард УИХ-д өргөн барьсан Эрүүгийн шинэ хуулийн төсөл юм. Хуулийн төсөлд цаазаар авах ялтай холбогдох бүх заалтуудыг хасч, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцийн 1-р зүйлийн дагуу эрүү шүүлтийн тодорхойлолтыг зааж өгсөн байна. Гэвч өмнөх Эрүүгийн хууль шигээ заавал биелүүлэх тушаалд үндэслэн хүний эрхийг зөрчсөн аливаа үйлдлийг ял шийтгэлгүй үлдээн, хамгаалалт тогтоосонгүй. Олон Улсын Эрүүгийн Шүүхтэй бүрэн хамтарч ажиллах, геноцид, дайны, хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах, үндэсний шүүхээр хэлэлцэхээр заасан нь Монгол улсын Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмээр хүлээсэн үүрэгт нийцсэн байна.<sup>6</sup>

2014 оны 7-р сард УИХ-д Хүчээр алга болгохоос бүх хүмүүсийг хамгаалах тухай олон улсын конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг өргөн барьсан ч хараахан хэлэлцээгүй байв.

## **Цаазаар авах ял**

2010 оны 1-р сард Монгол улсын Ерөнхийлөгч цаазаар авах ялын гүйцэтгэлд моратори зарлаж, өршөөл хүссэн бүх хүний ялыг хөнгөрүүлсэн. 2009 оноос хойш нэг ч цаазаар авах ял гүйцэтгээгүй байна.

2012 оны 3-р сард Монгол улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халах тухай Нэмэлт II Протоколыг соёрхон баталсан ч үндэсний хууль тогтоомждоо тусгаж хэрэгжүүлээгүй байна. Цаазаар авах ялыг хассан эрүүгийн шинэ хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.

Цаазаар авах ялын хэрэглээ нь Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалтын тухай хуулийн дагуу төрийн нууцын зэрэглэлтэй хэвээр байна. Цаазаар авах ялтай хүмүүсийн гэр бүлд ял гүйцэтгэх тухай урьдчилан мэдэгддэггүй, цогцсыг нь гэр бүлд нь өгдөггүй. Одоогийн байдлаар Төрийн нууцын зэрэглэлийг өөрчлөх ямар ч санаачлага гараагүй байна.

## **ХҮНИЙ ЭРХИЙН БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ**

### **Эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгийгээр харьцах бусад хэлбэрүүд**

Хэрэг хүлээлгэхийн тулд эрүүдэн шүүж, хүнлэг бус, хэрцгийгээр харьцах хүний эрхийн ноцтой зөрчил санаа зовоосон асуудал хэвээр байна. Цагдаагийн газрууд, түр саатуулах байруудад хоригдсон хүмүүсийг эрүүдэн шүүсэн, тэдэнтэй хүнлэг бус, хэрцгийгээр харьцсан хэрэгт сэжиглэгдсэн цагдаа нар, шоронгийн харгалзагчдад ямар ч хариуцлага хүлээлгэхгүй байна. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийг одоогийн Эрүүгийн хуулиар хориглосон хэдий ч, эрүү шүүлт ба хэрцгий, хүнлэг бусаар харьцсан хэргүүдийг мөрдөн шалгах бие даасан механизм байхгүй, түүнчлэн Эрүүгийн хууль дахь эрүүдэн шүүхийн тодорхойлолт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын Конвенцид заасан тодорхойлолттой нийцэхгүй байгаа, гэрчийн этгээдийг дарамтлах, өс хонзон авах зэргээс үүдэн эрүүдэн шүүхийн хохирогчдод шударга ёсыг олж авахад олон саад болж байна.<sup>7</sup>

Одоогийн байдлаар хууль сахиулах албаныхны үйлдсэн эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бусаар харьцсан хэргүүдийг мөрдөн шалгах хараат бус механизм байхгүй байна. Монгол Улсын засгийн газар УЕПДМБА-ыг бэхжүүлэх зөвлөмжийг хүлээн авч байсан ч тус алба 2014 оны 1-р сард татан буугдсан.<sup>8</sup> УЕПДМБА нь прокурор, шүүгч, цагдаа нарын албадлага, дарамт шахалтын эсрэг ирсэн гомдлуудыг мөрдөн шалгах үүрэгтэй байсан юм. УИХ-ын 22-р тогтоол болон 2014 оны 1 сард Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр эрүүдэн шүүж, хэрцгий, хүнлэг бус харьцсан тохиолдлуудыг мөрдөн шалгах үүргийг цагдаагийн газарт өгсөн байна. Энэ нь эрүүдэн шүүсэн хэрэг, гомдлуудыг орон нутгийн цагдаа нар, эсвэл хамтран ажилладаг нөхөд нь мөрдөн шалгах нөхцлийг бүрдүүлж байна.

2014 оны 2-р сард Архангай аймгийн цагдан хорих төвд хоригдож байхад нь хэрэг хүлээлгэхийн тулд цахилгаан бороохойгоор цохиулж, зодсон хэмээн гурван иргэн Монголын Хүний Эрхийн Үндэсний Комисст гомдол гаргажээ. Тэдний нэг нь гэм буруу хүлээлгэхийн тулд албадан шахаж, 6 өдрийн турш хоол өгөөгүй хэмээн мэдүүлжээ. УЕПДМБА нь татан буугдсан байсан тул Архангай аймгийн цагдаагийн хэлтэс энэ хэргийг мөрдөн шалгаж, улмаар эрүүдэн шүүж, хэрцгий, хүнлэг бусаар харьцсан талаарх гомдлыг хүчингүйд тооцсон байна.<sup>9</sup>

### **Орон байртай байх эрх**

Монгол улсын ДНБ 2013 онд 11.7% -иар өсч, Монгол улс дэлхийн хамгийн хурдан өсөж буй эдийн засагтай орнуудын нэг болоод байна.<sup>10</sup> Зах зээлийн эдийн засгийн шилжилт, өвөлжилт удаа дараа хүндэрсний улмаас хөдөө орон нутгийн иргэд хот руу маш ихээр шилжин суурьших болсон. Монгол

улсын нийслэл Улаанбаатар хотын хүн ам 1989 онд 600,000, 2007 онд 1 сая гаруй, харин 2015 онд 1.3 сая болох төлөвтэй байна. Гэр хороололд (нийтийн үйлчилгээ дутмаг, төлөвлөгөөнд ороогүй зарим газрууд) суугаа хүн амын тоо одоогийн байдлаар хотын нийт хүн амын 60 хувийг бүрдүүлж байна.<sup>11</sup>

2007 оноос хойш 7-р бичил хорооллын оршин суугчдыг тэдэнтэй зөвлөлдөж, хууль зүйн ямар нэг хамгаалалт, зөвлөгөө өгөхгүйгээр орон гэрээс нь албадан нүүлгэсээр байгаа аж. Түүнчлэн, барилгын хувийн компаниуд зарим оршин суугчдыг айлган сүрдүүлж, ус, цахилгааныг нь тасдсан тохиолдлууд гарсан байна. Эмнести Интернэшнл 2007 онд 7-р бичил хорооллоос нүүсэн зарим нэг иргэдээс барилгын компаниуд тэднийг шинэ орон сууцанд оруулна гэж амласан боловч өдийг хүртэл амлалтаа биелүүлж, орон байраар хангаагүй байгаа талаар мэдээлэл авсан. Оршин суугчид компаниуд тэдэнд “Нийслэлийн Иргэдийн хурлын Тэргүүлэгчдийн 23-р тогтоол”-оор “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам”-д орсон нэмэлт өөрчлөлтийн талаар худал тайлбар өгч, газраа нэн даруй зарахыг шаардаж, үгүй бол НИХТ-ийн 23-р тогтоолд заасан нөхөн төлбөрийг олгохгүй хэмээн сүрдүүлсэн байна.

Гэр хорооллын оршин суугчид шаардлага хангасан орон байртай байх, усан хангамж, нийгмийн үйлчилгээ хүртэх зэрэг энгийн үйлчилгээгээр хангагдах боломж маш дутмаг байдаг.<sup>12</sup> Хотын гэр хороололд амьдарч буй хүүхдүүд шаардлага хангасан боловсрол, хоол тэжээлээр хангагдах боломж хязгаарлагдмал байдаг.<sup>13</sup>

### **Ялгаварлан гадуурхалт**

Эмнести Интернэшнл Монгол улсад нийгмийн цөөнх болон бусад дарамт шахалтад буй бүлэг хэсгийн эсрэг, ялангуяа боловсрол ба шүүх, хууль зүйн хүрээний ялгаварлан гадуурхалтын талаар мэдээлэл тогтмол хүлээж авдаг. Ялгаварлан гадуурхалт нь хувь хүний эрх цаашид улам их зөрчигдөх эрсдлийг үүсгэж, халдлага хүчирхийллийн тохиолдлууд мэдэгдэлгүй өнгөрч, гэмт хэрэг үйлдэгч нь ял шийтгэлгүй өнгөрөх нөхцлийг бий болгодог. Ял шийтгэлгүй өнгөрөх явдал нь эрх мэдэл бүхий хүмүүсийн эсрэг арга хэмжээ авах иж бүрэн хуулийн хамгаалалт, механизм байхгүйгээс үүдэж байна. Одоогийн байдлаар бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтын талаар болон ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байх эрхийг хамгаалах ямар ч хууль тогтоомж байхгүй байна.<sup>14</sup>

Хүйс эсвэл бэлгийн чиг хандлагаас үүдсэн дайсагнасан, ялгаварлан гадуурхсан хандлагууд нь Эмнести Интернэшнлийн анхаарч буй асуудлуудын нэг хэвээр байна. Хүйс ба бэлгийн чиг хандлагаас үүдэлтэй ялгаварлан гадуурхалтаас хамгаалах дотоодын хууль тогтоомж байхгүй байна. Лесби, гей, бисекс, трансжэндэр болон интерсекс хүмүүсийн эсрэг халдлага, дайралтын албан тоо баримт буурч байгаа ч засгийн газар өмнөх Ээлжит нэгдсэн дүгнэлт хэлэлцүүлгээс гаргасан ЛГБТИ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг хориглох зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй байна.<sup>15</sup> Нэгэн идэвхтэн Эмнести Интернэшнлд бэлгийн хүчирхийлэл, халдлагад өртсөн хүмүүс цагдаа нараар нэмж доромжлуулах, эсвэл эргээд өс хонзонгийн бай болохоос айсандаа эрх баригчдад гомдол гаргадаггүй гэж хэлсэн. Ялгаварлан гадуурхалтад өртсөн нэгэн хохирогч хүйс буюу мөн бэлгийн чиг хандлагаас нь болж тэдэнд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан тухай ярьжээ.

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт хэрэв хохирогч нь эрэгтэй бол практикт хүчиндүүлсэн гэж тооцогддоггүй байна. Тиймээс, бэлгийн хүчирхийллийн эрэгтэй хохирогчдод шаардлагатай эмчилгээ, нөхөн олговор авах, шүүхэд хандах, гомдлоо барагдуулахад ихээхэн хүндрэлтэй байдаг байна. Эрэгтэй хүнийг хүчиндсэн хэрэгт Эрүүгийн хуулийн 125-р зүйлийн дагуу зөвхөн “бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан” хэмээн ял оногдуулдаг байна.

### **Дүрвэгчид ба орогнол хүсэгчид**

2014 оны 5-р сард Монгол Улсын засгийн газар Өвөр Монголын Өөртөө Засах Орноос ирсэн хоёр орогнол эрэгчийг БНХАУ-руу албадан буцаасан байна. Гэтэл тухайн үед НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газраас тэдний нэгэнд дүрвэгчийн статус өгөхөөр шалгаж байсан бөгөөд энэ

нь “non-refoulement” зарчмыг зөрчсөн явдал болсон юм. Одоогийн байдлаар Монголын хууль тогтоомжинд олон улсын эрх зүйн зан заншлын энэхүү зарчмыг тусгаагүй байна. Монголын засгийн газраас орогнол олгох тогтолцоог хэрэгжүүлж, зохицуулдаггүйн улмаас НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар Монголд орогнол эрэгчдийг бүртгэж, баримтжуулан, тус улсад дүрвэгчийн статус авахад анхааран ажиллаж байна. Гэвч НҮБ-ын ДАЭДКГ-тай холбогдох орогнол эрэгчдийн тоо хязгаарлагдмал хэвээр байна.

## ТӨРИЙН ЗҮГЭЭС АВАХ АРГА ХЭМЖЭЭНД ӨГӨХ ЗӨВЛӨМЖҮҮД

**Эмнести Интернэшнл Монголын засгийн газрыг дараах алхмуудыг хэрэгжүүлэхийг уриалж байна:**

### *Үндэсний хууль тогтоомж*

- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт Протокол, Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны Конвенц, түүний 1967 оны Нэмэлт Протокол, түүнчлэн Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц, Хүчээр алга болгохоос бүх хүмүүсийг хамгаалах олон улсын конвенцыг соёрхон батлахыг уриалж байна.

### *Цаазаар авах ял*

- Олон улсын хүний эрхийн эрх зүй, хэм хэмжээнд нийцсэн цаазаар авах ялыг халсан хууль тогтоомж, шинэ Эрүүгийн хуулийг батлах;
- Цаазаар авах ялын асуудлаарх нууцлалыг төгсгөл болгож Төрийн нууцын тухай хууь, Төрийн нууцын жагсаалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, цаазаар авах ялын асуудлаарх бүх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох.

### *Эрүүдэн шүүх болон хэрцгий, хүнлэг бусаар харьцах бусад хэлбэрүүд*

- Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцид заасны дагуу эрүүдэн шүүхийн тодорхойлолтыг өөрчлөх;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцсан талаарх бүх гомдол, мэдээллийг хараат бус байгууллага мөрдөн шалгаж, холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэхийг баталгаажуулах. Энэ төрлийн гэмт хэрэгт эрүүдэн шүүгч болон түүний ажилладаг байгууллагаас ангид хараат бус, шударга, чадвар бүхий бие бүрэлдэхүүн мөрдөн шалгах ажиллагаа явуулах ёстойг баталгаажуулах.

### *Орон байртай байх эрх*

- Гэр хороололд амьдарч буй иргэдийн эсрэг шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалттай тэмцэх арга хэмжээ авах;
- Албадан нүүлгэлтийг хууль тогтоомжоор хориглож, шинэ хот төлөвлөлт, хөгжлийн хуульд газрын худалдаа, дахин төлөвлөлтөөс үүдэн гарах нүүлгэн шилжүүлэлтийг харгалзан үзэж, иргэдийн эрх ашгийг хамгаалах. Эдгээр хууль нь хөгжлөөс үүдсэн нүүлгэн шилжүүлэлтийн талаарх НҮБ-ын суурь заавар, зарчмуудад үндэслэсэн байх ёстой.

### *Ялгаварлан гадуурхалт*

- Ялгаварлан гадуурхалттай тэмцэх шинэ хууль тогтоомж гаргах. Үүнд ялгаварлан гадуурхалт, дайсагнасан үзэл, хүчирхийллийг өдөөн хатгасан аливаа сурталчилгааг хориглох тухай багтаах;
- Хүйс ба бэлгийн чиг хандлагаасаа болж хүчирхийлэлд өртсөн хувь хүмүүсийн гомдол, мэдүүлгийг нэн даруй мөрдөн шалгаж, холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх;

- ЛГБТИ хүмүүст эрхийг нь эдлүүлэх явдлыг хангаж, тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх явдлыг хөхиүүлэн дэмжиж, шинэ үндэсний хууль тогтоомж гаргах;
- Хохирогчдын хүйсээс үл шалтгаалан хүчирхийлэл үйлдэгч нь тохирох ял шийтгэл хүлээх явдлыг хангах.

### *Дүрвэгсэд ба орогнол хүсэгчид*

- Гадаад иргэний эрх байдлын тухайн хуулийг дахин хянаж, орогнол эрэгчдийг хүний эрхийн ноцтой зөрчилд өртөж болзошгүй улсруу нь буцаах явдлыг хориглох;
- Монголд орогнол хүсэгч бүх хүмүүст НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газартай холбоо барих боломж олгож, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газраас дүрвэгчийн статусыг тодорхойлоход хөндлөнгөөс оролцохгүй байх.

## ЗҮҮЛТ

<sup>1</sup> Report of the Working Group on the Universal Period Review, A/HRC/16/5, 4 January 2011, paragraphs 84 -86.

Three rejected recommendations are the recommendations to become a party to the 1951 Convention relating to the Status of Refugees and its 1967 Protocol and the International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of Their Families, and the recommendation to “mandate the Constitutional Court to act upon violations of individual rights and freedoms guaranteed under the Constitution.

<sup>2</sup> The National Plan of Action (NPA) constitutes of 62 plans of actions of the government of Mongolia developed based on 126 recommendations made during the previous UPR session.

<sup>3</sup> Ibid, recommendations 7 (Brazil), 8 (Spain), 9 (Sweden), 10 (Portugal), 15 (Switzerland) and 66 (Argentina) and 22 (The Netherlands).

<sup>5</sup> Ibid, recommendations 121 (Argentina) and 122 (Norway).

<sup>6</sup> Article 44.1 of the current Criminal Code provides that acts causing harm to the rights and interests protected by the Criminal Code do not constitute a crime if those acts were committed in the course of carrying out mandatory orders. This article risks leading to impunity for law enforcement officials, including for acts violating the right to life or acts of torture.

<sup>7</sup> In 2013, National Human Rights Commission of Mongolia received 669 complaints, 289 of them (43.2%) were received from prisons and detention centers. 116 concern alleged acts of torture committed by police officers, investigators, and case registrars. 18% of complaints relate to the pre-trial detention process and ethical conduct of investigators.

The National Human Rights Commission of Mongolia “13th Report on Human Rights and freedoms IN Mongolia” <http://www.mn-nhrc.org/files/iltgel-2009.pdf>

<sup>8</sup> Report of the UPR Working Group (A/HRC/16/5) recommendations 97 (Canada).

<sup>9</sup> The National Human Rights Commission of Mongolia “13th Report on Human Rights and freedoms IN Mongolia”.

<sup>10</sup> The World Bank, Global economic prospects 2014: shifting priorities, building for the future.

<http://www.worldbank.org/content/dam/Worldbank/GEP/GEP2014b/GEP2014b.pdf>

<sup>11</sup> The World Bank, Mongolia: Enhancing Policies and Practices for Area Development in Ulaanbaatar, p.1.

[http://siteresources.worldbank.org/INTMONGOLIA/Resources/Full\\_report\\_in\\_Eng.pdf](http://siteresources.worldbank.org/INTMONGOLIA/Resources/Full_report_in_Eng.pdf). A *ger* is the name of a traditional dwelling in Mongolia, it's a tent made of felt traditionally used by nomads in Central Asia.

<sup>12</sup> Cities Alliance Project Output, Citywide Pro-Poor Ger Area Upgrading Strategy of Ulaanbaatar City, pp.39-40.

[http://www.citiesalliance.org/sites/citiesalliance.org/files/CAFiles/Projects/GUSIP\\_Output\\_1.6 - Citywide Pro-poor Ger-area Upgrading Strategy December2010reduced.pdf](http://www.citiesalliance.org/sites/citiesalliance.org/files/CAFiles/Projects/GUSIP_Output_1.6_-_Citywide_Pro-poor_Ger-area_Upgrading_Strategy_December2010reduced.pdf). WHO, Country cooperation strategy for Mongolia 2010-2015, p.16

[http://www.who.int/countryfocus/cooperation\\_strategy/ccs\\_mng\\_en.pdf](http://www.who.int/countryfocus/cooperation_strategy/ccs_mng_en.pdf). The World Bank, Enhancing Policies and Practices for Ger Area Development in Ulaanbaatar, [http://siteresources.worldbank.org/INTMONGOLIA/Resources/Full\\_report\\_in\\_Eng.pdf](http://siteresources.worldbank.org/INTMONGOLIA/Resources/Full_report_in_Eng.pdf)

<sup>13</sup> UNICEF, Situation analysis of children and women in Mongolia, p.27. [http://www.unicef.org/sitan/files/SitAn\\_Mongolia\\_2009.pdf](http://www.unicef.org/sitan/files/SitAn_Mongolia_2009.pdf)

<sup>14</sup> Report of the UPR Working Group (A/HRC/16/5), recommendations 84.49 (Ukraine) and 86.5 (Mexico).

<sup>15</sup> Ibid. recommendations 19 (Canada), 58 (Netherlands), 59 (Switzerland), 60 (Canada), 98 (Sweden), 101 (Sweden) and 128 (Spain).

Монгол улс: НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэгт зориулсан Эмнести Интернэйшнлийн илтгэл 2014 оны 10 дугаар сар